

НИШИДА КИТАРО БА ХХ ЗУУНЫ ЯПОНЫ ФИЛОСОФИ

Д. ОЮУНГЭРЭЛ, ХААИС-ийн багш, МУИС-ийн докторант

Түлхүүр үг. Басё (basho), ахуй, "эс оршихуйн диалектик", "цэвэр туршлага" /pure experience/, интуици.

ХХ зууны Японы түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн түүхэн хүний нэг бол Нишида Китаро (1870-1945) юм. Олон жилийн туршид уламжлалаа хатуу баримтлан хаалттай байсан Япон оронд Өрнө дахины соёл, боловсролын янз бүрийн чиглэлийн ололтыг нэвтрүүлэн оруулж ирэхэд энэ философич идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн байна. Япон орныг өнөөгийн энэ өндөр хөгжлийн түвшинд хүрэхэд ч түүний философийн үзэл санаа зэрэг нөлөө үзүүлсэн гэж судлаачид үздэг. Тэрээр Японы философийг Өрнөчлөх замаар Өрнийн болон Дорнын философийн аль алины шилдэг ололтыг нэгтгэсэн өвөрмөц философийн үзэл боловсруулахыг зорьж байжээ.

Нишида Китаро нь 1870 онд төржээ. Тэрээр Каназава хотын сургуульд суралцаж мэдлэг, боловсрол олж авсан бөгөөд анх Күнзийн шинэтгэсэн сургаал, сонгодог Даосизмыг сонирхон судалж байсан гэдэг. Үүний зэрэгцээ тэрээр Кант болон Гегелийн үзэл санаа, бүтээл туурвилуудыг судалж, их сургуульд суралцаж байх хугацаандаа Кант, Гегель, Шопенгауэр нарын үзэл санаа, бүтээл туурвилыг гүнзгийрүүлэн судалж эхэлжээ. Их сургуулиа төгсөхдөө (1884) "Д.Юмын учир шалтгааны онол" сэдэвт дипломын ажил бичиж хамгаалсан байна. Тэрээр сургуулиа төгссөний дараа дунд сургуульд багшилж байжээ.

Нишида 1914 онд философийн ухааны профессор цолыг хүртэж, 1910-1927 онд Киотогийн их сургуулийн профессороор ажилласан бөгөөд энэ үеэс түүний философийн үзэл санааны үндэс нь тавигдсан гэж үздэг юм байна.

Түүний гол бүтээлүүд нь "Сайн үйлийн тухай сургаал" (*A Study of Good*) (1911)/ *Zen no Kenkyu*/, "Өөрийгөө танин мэдэх зөн (интуиц), эргэцүүлэл хоёр" (1917) "Хоосны өөрийгөө ухамсарлагч тодорхойлолт" (1923), "Их үйлсээс харагдахуйд" (1927) *From That Which Acts to That Which Sees* (1927), "Зүй тогтол, амьдрал хоёр" (1936), "Басё (basho)-ийн зүй тогтол, шашны үзэл хоёр" (1945) зэрэг зохиолууд юм.

ХХ зууны эхэн үеийн Японы философийн гол үзэл санаа материалист, шашингүйн үзэл давамгайлах байдлаар тодорхойлогдож байв. Тухайлбал, Японы анхны философич Накаэ Тёмины материалист үзэл санааны сургаал энэ үйл явцад чухал үүрэг гүйцэтгэжээ. Энэ үед Котоку Сюсуй, Ката Ямасэн зэрэг олон социалист хөдөлгөөний зүтгэлтнүүд гарч, материалист философийг дэлгэрүүлэхэд идэвхтэй ажиллаж байжээ. Мөн Маркс, Энгельс нарын бүтээлүүдийг орчуулах гаргахын зэрэгцээ мөн нийгмийн асуудалд чиглэсэн Японы социалистуудын бүтээлүүд хэвлэгдэн Японд марксизм дэлгэрэх эхлэл тавигдсан байна.

Тэр үед залуу сэхээтнүүд өөрийн уламжлалт Синто-Күнзийн сургаал номлолоос илүү Европын философийн тогтолцоог илүүд үзэх болсон байна. Тухайлбал, 1870-аад оноос тэдний сонирхлыг О.Конт, Ж.С.Милль, Ч.

Дарвин зэрэг эрдэмтдийн үзэл баримтлал, 1890-аад оны үед Германы философичид болох Кант, Гегель, Шопенгауэр нар тэдний сонирхлыг ихээхэн татаж байжээ. Мөн Ницше, Бергсон, Толстой, Уиллям Жеймс нарыг мөн идэвхитэй судалж байв¹.

Хэдийгээр тухайн үеийн ихэнх сэхээтнүүд гадаадын мэдлэгийн системийг төдийлөн эрхэмлэхгүй байсан хэдий ч өөрсдийн уламжлалт Буддын болон Күнзийн сургаалийн мөн чанартай харьцуулахад ижил төстэй зүйл Өрнөдийн философид байгааг олж мэдсэнээр, тэд барууны философийг илүү судлахыг зорьсон байна. Тэдний энэхүү байр суурь нь Барууны философийг шууд хуулбарлах бус, харин асуудалд шүүмжлэлтэй, бүтээлч сэтгэхүйн үүднээс хандах явдал байлаа. Ингэснээрээ XIX зууны хоёрдугаар хагас гэхэд Японы сэхээтнүүд Европын болон Америкийн философийг нэвтрүүлж эхэлсэн байв.

Гэвч XX зууны эхэнд энэ бүх байдал аяндаа өөрчлөгдөж эхэлсэн бөгөөд Өрнийн болон Дорнын хоёулангийнх нь ертөнцийг үзэх үзлийн синтез руу чиглэсэн оролдлого гарч яг энэ цаг үед Нишида Китаро өөрийн философийн үзэл баримтлалынхаа суурийг тавьжээ.

Нишида Китарогийн философийн үзэл санаанаас

Япон орон даяар Мэйжийн шинэчлэлийн үе хэмээх түүхэн үйл явц эхэлсэн тэр үед Япон оронд Өрнөдийн соёл, боловсрол, техник технологи нэвтрэн орж ирсэн явдал бол ихээхэн ач холбогдолтой зүйл байжээ. Яг энэ цаг үед Японы ард түмний оюун санааны ертөнцөд өрнийн тэр дундаа эртний Грек, Герман, Английн философийн үзэл санаагаар дамжуулж философийн сэтгэлгээнд нэгэн өвөрмөц алхам хийсэн хүн бол профессор Нишида Китаро юм.

Нишида Китарогийн үзэл санааны эх сурвалж нь зэн буддизм байсан бөгөөд тэрээр Дорнын философийн уламжлалт сэтгэлгээг барууны философийн системийн хэв маягаар өөрчлөх гэж олон жил оролдож, үүнийхээ үр дүнд Японы философийн нэгэн өвөрмөц чиглэл болох "универсаль философи"-ийн суурийг тавьж чадсан юм.

Ийнхүү Нишида Китаро ёс зүйн чиглэлээр зохиол бүтээлээ туурвиж, хүний дотоод амьдралд голлон анхаардаг зэн буддизмыг илүүд үзэж, зэн буддизмын онолын үндэслэгээг хайж, барууны философийг сонирхон судлах болжээ.

Гэвч энэ бүх судалгааны эцэст иррационалист үзэл санаа Нишидагийн сонирхлыг илүү их татжээ. Тэрээр зэн буддист Д. Судзукид (1870-1966) илгээсэн захидалдаа "Өнөө үеийн Европын ёс зүй, оюун ухаан, шинжлэх ухаанд бүрэн чиглэжээ. Тэнд маш нарийн зүйлс хэлэлцэгдэж байгаа боловч, Европын сэтгэгчдээс хүний сэтгэлийн гүнд нэвтэрсэн хүн алга. Харин бүхний үндэс нь санаа зорго гэж үзсэн Шопенгауэрийн онол, амгалан бясалгалын тухай онол болох Гегелийн онол бусдынхаас илүү сонирхолтой гүнзгий юм" гэж бичжээ. Ийнхүү Нишида рационалист философид шүүмжлэлтэй хандаж, шашны философид илүү шимтэж, зөвхөн шашинтай хүмүүсийн бишрэлээр орчлонг хүн танин мэднэ. Ийм учраас хэрвээ философич үнэхээр үнэнд хүрэхийг зорьж байгаа бол эцэстээ

¹ www.reproutledge.com

иррационализмд орох ёстой хэмээжээ. Нишида шинжлэх ухааны философийн мэдлэг, шашин хоёр эсрэг, тэсрэг гэдгийг ухамсарлахгүй өнгөрөхгүй нь ойлгомжтой. Эндээс л түүний ямар нэг эклектик онол бүтээх зорилго бүхий амаргүй эрэл хайгуул эхэлжээ.

Нишида "Сайн үйлийн тухай сургаал" хэмээх анхны бүтээлдээ философийн хайгуулын энэ талаар тусгасан байна. Тэрээр "Хүний амьдралын мөн чанар юунд орших вэ? жинхэнэ бодит байдал гэдэг юу вэ?" гэдгийг тайлбарлах зорилго тавьж, "бодит ахуй гэдэг бол ердөө л бидний ухамсрын баримт"¹ гэж үзэж байжээ. Түүнийг энэ үзэл санаа нь цэвэр буюу шууд туршлагад хөтөлжээ.

Нишидагийн философи дахь "Цэвэр туршлага"/pure experience/-ын тухай асуудал бол түүний философийн нэг гол ойлголт нь юм. Энэ ойлголт нь түүний дараа дараагийн хайгуулуудын нь гараа болж, философийн бүх асуудлуудад нь тусгагдсан байна. Нишида "цэвэр туршлага" гэдэг субъект, объект хоёр нь ялгараагүй нэгэн өгөгдөхүүн гэж үзэж, түүндээ мэдрэмж, санаа зорго, ухамсрыг багтааж байжээ. Нишида "ер нь ухамсрын үзэгдэл материйн үзэгдэл гэдэг бол туршлагын баримтуудын хоёр төрөл оршдог гэж бодож болно. Уг чанартаа нэг л оршдог. Энэ нь зөвхөн ухамсрын үзэгдэл юм. Материйн үзэгдэл ердөө л хүн бүхэнд нийтлэг байдаг хувиршгүй харилцаа бүхий юмны хийсвэрлэл юм.

Ийм учраас тэр нь ердөө л ухамсрын үзэгдлийн хэсэг нь мөн. Ухамсар бидний биед биш, харин бие бидний ухамсрын дотор байдаг. Нишида нь Ж.Берклийн "Юмс оршиж байна гэвэл хүртэгдэж байна гэсэн үг" гэдгээс зайлсхийж, жинхэнэ бодит байдал бол ухамсрын үзэгдэл ч гэж, материйн үзэгдэл ч гэж нэрлэж үл болох тийм нэг зүйл юм. Энэ нь бие даасан нэгэн түгээмэл үйл ажиллагаа юм. Эндээс л оршихуй тэнд үйл ажиллагаа болж сэтгэгджээ. Гэхдээ Нишидагийн үзлэр, үйл ажиллагаа нь эцэстээ "цэвэр туршлага" болж ирдэг ажээ. Түүний үзлээр "цэвэр туршлага" миний туршлага биш. Энэ нь миний туршлагын үндэс болж, би төлөвших үндсийг агуулсан ухамсрын эхний үйл явц юм. Цэвэр туршлага зөнгөөр (интуицээр) хүртэгддэг. Энэ нь субъект, объект заавал байхыг шаарддаг рефлексээс ангижирсан ухамсар юм.

Улмаар Нишида "цэвэр туршлага" гэдэг ойлголтоо бурхан гэдэг ойлголтод аваачиж, бодит байдлын үндэс нь бурхан юм гэж тунхаглаад, субъект, объект ялгаагүй тэр юм. Сүнс, байгаль хоёр нэгдсэн газар бол бурхан юм хэмээн үзжээ.

Үүний зэрэгцээгээр Нишида бурхны оршихуйг логикийн аргаар нотлох гэдэг баруун европын И.Кант зэрэг философичдийг шүүмжилдэг байжээ. Хүний сэтгэлийн хязгааргүй бие даасан ажиллагаа бурхан байгааг баталж байна. Ийм учраас бурхны үзэл санааг зөнгөөр хүртэх нь чухал гэж үзжээ. Философич уг асуудалд дорны шашны үзэл, баруун европын бурхны номлолын үзлээр ханджээ. XV-XVI зууны үед Европд дэлгэрсэн Энэтхэгийн шашин, агийн ёсны сургуулиуд бурхныг дотоод зөнд хайж байв. Энэ нь нэн

¹ Философский энциклопедический словарь. М., 1989. стр. 423

гүнзгий бурхныг танин мэдэхүй юм гэж би үздэг¹ хэмээн Нишида тэмдэглэн бичжээ.

Ийнхүү Нишидагийн анхны бүтээл болох "Сайн үйлийн сургаал" зохиол нь түүний шашны үзлийг бататгах, философийн үндэстэй болгох санааг агуулж байдаг.

1920-1930-аад оны Японы философийн хүрээнд Марксист-Ленинист онол хүчтэй нэвтэрсэн тэр үед Нишидагийн философийн үзэл санаа төлөвшжээ.

Харин Нишида марксизмын үзэл санааны эсрэг байжээ. Японд К.Марксын бүтээлүүдээс гадна, Гегелийн философийн өвийг хүчтэй судалж эхэлжээ. Үүний нэгэн тод жишээ нь 1931 онд Японд олон улсын Гегелийн холбоо байгуулагдаж, Гегельд зориулж олон ном зохиол хэвлэсэн явдал мөн. Гегелийн диалектикаас хувьсгалт агуулгыг нь хасаж, Марксыг шинжлэх ухааны бус аргаар тайлбарлахын тулд Японы хөрөнгөтний философичид "шүүмжлэлт диалектик", "бодит диалектик", "адилсалын диалектик" болон диалектикийн төрлүүдийн ойлголтыг томъёолжээ. Хэдийгээр Марксизмд шүүмжлэлтэй хандаж байсан хэдий ч Нишида бас марксист материалист диалектикийг судлаж байжээ.

Материалист диалектиктэй танилцах явцад Нишидагийн философи боловсорч гүйцжээ. Түүний философийн цөм нь "эс оршихуйн диалектик" гэгч үзэл бөгөөд 1930 онд боловсруулсан. Нишида Марксын диалектик бодит ертөнцтэй холбоотой учир үнэн биш гэж тодорхойлж байжээ. Нишидагийн үзлээр¹, жинхэнэ диалектик аливаа субстанц чанараас салсан, объектив зүй тогтол байхыг шаарддаггүй ухагдахуунуудад дэлгэрсэн байх ёстой аж. Тэрээр субъектив болон объектив, субъектив объектив чанарын аль алинд байгаа зүйлийг хүлээн авч бид бодит ертөнцийг дотроо сэтгэнэ. Ингэхлээр диалектик арга үнэмлэхүй диалектик арга байх ёстой. Бие биеэ нөхцөлдүүлсэн категоруудын диалектик арга үнэнхүү диалектик арга биш юм. Иймээс Гегелийн диалектик арга, Марксын диалектик аргын аль аль нь жинхэнэ диалектик арга биш юм гэж үзэж байжээ.

Мөн Нишида "Сайн үйлийн тухай сургаал" (1911) анхныхаа зохиолдоо Вундт, Джеймс нар цэвэр туршлагын ойлголтыг шүүмжилж байсныг нь үл харгалзан, тэдний үзлийг дэмжиж, тэдгээрийн үзэл санааг өөрийн бүтээлдээ авч үзжээ. Нишида "Өөрийгөө танин мэдэх зөн, эргэцүүлэл хоёр" хэмээх бүтээлдээ өөрийн үзлийг шинэ кантч үзэл, ялангуяа Г.Риккерт, А.Бергсон хоёрын эсрэг сөргүүлэн тавьсан байдаг. Энэ зохиолдоо өөрийн цэвэр туршлагын үзэл баримтлалаа Фихтегийн үзэл санаагаар баяжуулж, үнэмлэхүй зөнгийн үүднээс тавьжээ. Мөн өөрийн "Үйлдэгчээс бясалгалд" (hataraku mono kara miru mono e) хэмээх бүтээлийн оршил хэсэгт Нишида интуици нь санаа зоргын уг үндэс гэдгийг шууд тавьжээ. Тэрээр үйлдэх гэдэг нь бясалгана гэсэн үг. Энэ утгаараа үнэмлэхүй санаа зорго төгсгөлтэй. Энд тэрээр "харагдахуй", "бясалгал" гэдэг буддын үзэл санааг үйлдлийн болон "үл үзэгдэхүйг үзэх" үндэс болгожээ. Ийнхүү тэрээр өөрийн агийн ёс (мистик)-ны зөнг логик үндэстэй болгохыг оролдож байжээ.

¹ История современной зарубежной философии. Санкт-петр бург М., 1997, ст. 435-445

¹ www.stanford.encyclopedia

Түүнчлэн Нишида европын философи, логик хоёр универсаль шинжтэй хэмээн тайлбарлаж байжээ. Тэгэхдээ универсаль шинж бол Европын философийн ганц шинж биш гэжээ. Бас тэрээр Дорно дахины сэтгэлгээний арга ч универсаль шинжтэй гэдгийг онцлон тэмдэглэсэн буй. Тэрбээр туйлын эс оршихуй бол төгсгөлт бодит чанар юм гэж үзэж, барууны философитой сөргөлдөн туйлын эс оршихуйн логик үндэслэгээг гаргахыг оролдож байжээ. Үүгээрээ тэр Масао Абэ-гийн тэмдэглэснээр, дорнын ч биш, өрнийн ч биш, дэлхийн шинэ универсаль философийг бүтээхийг эрмэлзэж байжээ.

Нишида нь Германы экзистенциалист Хайдеггерийн бүтээлүүдтэй танилцаж, түүний туйлын ахуйн үзэл баримтлал Гегельтэй ихээхэн холбоотой гэж үзэв. Мөн Нишида нь Европ, Хойд Америкийн өөрийн үеийн философичдын бүтээлүүдтэй өргөн танилцсан хүн юм. Ийнхүү Нишидагийн философийн бүтээлүүд эртний үеэс орчин үе хүртэлх барууны философийн үзлийг шүүн тунгаахад чиглэсэн байна.

Орчин үеийн компаративист (харьцуулах) философид Нишида чухал байр суурь эзэлдэг байна. Тэрээр 1927-1945 оны хооронд өөрийн "Зөрчлийн онол"-оо боловсруулжээ. Тэрээр цэвэр туршлагын, үнэмлэхүй эс оршихуйн үзэл баримтлалдаа логик үндэслэгээ хийх зайлшгүй хэрэгцээний улмаас Аристотель, Гегель, Марксын диалектик, логикийн ойлголттой санал зөрж, шүүмжилсэн зүйлүүд багагүй бий. Мөн тэрчлэн диалектик бус тайлбарлал болох феноменологид шүүмжлэлтэй хандаж байжээ.

Нишида хэлэхдээ: "тодорхой юм л универсаль шинжтэй. Тэр нь универсаль "mu" буюу "эс оршихуй" болж хөгждөг" гэжээ. Тэрээр өөрийн логикийг субъект болдоггүй "өгүүлэхүүний логик" гэж тодорхойлж, энд "хэлбэр", "хэлбэргүй байдал", эн тэнцүүхэн өдөөгч бодит байдлын шинж төрх гэж үзэж байв. Нишида диалектик, орон зайн логиктоо үргэлжлэх ёсыг Бергсонтой төстэй атлаа буддын философийн уг язгуур бүхий хөрсөн дээр тавьжээ. Түүний "орон зайн логик" нэгэн зэрэг үгүйсгэж баталдаг олон эшт онтологитой холбоотой.

Ингэхдээ экзистенциалист философиос "хүний ахуй" хэмээх ойлголтыг уламжлан, "басё" \basho\ хэмээх ойлголтоор хэрэглэсэн буй. Энэ нь "Эс оршихуйн орон зайн логик"-т тод ажиглагддаг байна. Чухамдаа энд эс оршихуйн логикийн үндсэн дээр тулгуурлан шашны ухамсрын ойлголтоо боловсруулжээ. Нишидагийн философид зөрчил онцгой байр суурь эзэлж, зөрчил бол "би" (өөрийгөө зөвтгөх сэтгэлгээ) орчин хоёрын төвлөрсөн сэтгэлгээний хэлбэр юм гэж үзэж, "үйлдэл зөн" хоёрын холбоогоор л ертөнцийг үзэхүй хэрэгждэг гэж үзэж байжээ.

Нишидагийн үзлээр, "үнэмлэхүй эс оршихуй" бие шинжээ тодорхой бодгальд зуршсан чанаруудын цогцолбор төлөвшдөг, тэр үнэмлэхүй эс оршихуйн "орон зай" нь юм. Ийм бодгаль логик болон бодитой хоёр онцлог эзэмшдэг. Тэр нь эхлээд өөртэйгөө, тэгээд дотоод зөрчлийг бүхэл бүтэн цуврал зөрчил, жишээлбэл, амьдрал, үхэл хоёрын үнэмлэхүй зөрчлүүдтэй ижилсдэг. Энэ бол бодгалийн бодит онцлогуудын талаарх "үнэмлэхүй одоо" гэгч тодорхой байр суурь нь юм. Угтаа буддын утга үнэмлэхүй эс оршихуй хоосон орон зайг тайлбарлах логик дэг ёсны нь онцлог болж байжээ. Эцэсдээ үнэмлэхүй эс оршихуй, үнэмлэхүй зөрчлүүд өөртөө адилсахуй болж байв.

gibegolov-na-bolnais-vmv

Нишида Китарогийн философийн үзэл санаа нь зарим талаар Сартрын философийн үзэл баримтлалтай холбоотой гэж хэлж болно. Тухайлбал, нэгдүгээрт, Нишида "би"- өөрийгөө ухамсарлагч эс оршихуйн өөрийн ухамсар юм гэжээ. Харин Сартр "би" - субстанциаль бус нигилист гэжээ. Хоёрдугаарт, өөрийгөө зөвтгөгч "би" гэдгээ тайлбарлахдаа зөвхөн тухайн байдалд л адил шинжтэй гэдгээрээ төстэй. Гуравдугаарт, тэд амьдралын түгшүүрийг тайлбарлахдаа төстөй байдаг. Тэглээ ч Нишидагийн эс оршихуйн философи, Сартрын "оршихуй, эс оршихуй хоёр" философийн хооронд Нишидагийн шашны сэтгэлгээ, Сартрын шашингүйн үзлийн хооронд ялгаа бий. Энэ нь философи шашин, ухамсар, өөрийн ухамсрын харилцаа, үхлийн асуудлыг өөр өөрөөр тайлбарлаж байжээ гэсэн үг. Ийнхүү Нишида эс оршихуйн философидоо буддын философийн үндэс, барууны философийн онтологи, танин мэдэхүйн сургаалуудыг холбохыг оролджээ.

Түүнийг нас барсны дараа үзэл баримтлалыг нь олон шавь нар нь өвлөн авсан төдийгүй Нишидагийн философи сургаал Японы үндэсний онолд тооцогдож, Өрнийнхөн өнөө болтол түүнийг Японы философийн суу билэг гэж өргөмжилж иржээ.

Дүгнэлт

Нишида Китарогийн философийн онцлог нь дорнын соёлын өвөрмөц шинж байдалд тулгуурласанд оршино. Мөн тэрээр дорнын философи нь барууны философиос ялгаатай болохыг харуулахыг зорьсон.

Нишида өөрийн философийг буддизмаас гаралтай дорны философи гэж тодорхойлсон байдаг. Онолын хувьд Нишида барууны философид анхаарлаа хандуулж, иррационалист урсгал чиглэлийг илүүтэй судалсан буй. Нишидагийн философи нь барууны философиос экзистенциализмтай илүү ойрхон үзэл баримтлал юм.

Ном зүй

www.reproutledge.com,
www.stanford.encyclopedia

История современной зарубежной философии. Санкт-петр бург М., 1997
Философский энциклопедический словарь. М., 1989

An inquiry into Good . Kitaro Nshida. Translated by Masao Abe and Christopher Ives. New Haven Yale University press, 1976